

## МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ИХ ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ ХУУЛЬЧ ТАНАА

Шинэ бодлого  
Шинэ арван

Монголын Хуульчдын Холбоо нь дэвшилтэд бодлоготой, хуульчдынхаа эрх, ашгийг тууштай хамгаалдаг, гишүүдийнхээ санал, санаачилгыг дэмждэг, цомхон, чадварлаг, үйл ажиллагааны болон санхүүгийн мэдээлэл нь ил тод, нээлттэй, гишүүдээ илүү мэргэшүүлэх, үнэлэмжийг нь дээшлүүлдэг байгууллага байх ёстой.

Манлайлан хэрэгжүүлдэг, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн хууль тогтоомжийн төсөл боловсруулж хууль санаачлагчдад уламжилдаг, нягт хамтран ажилладаг, хуульчдын судалгаа, бүтээлийг хууль санаачлах, боловсруулах үйл ажиллагаанд бүрэн ашиглах боломж, нөхцөлийг бүрдүүлсэн бүтээлч байгууллага байх ёстой.

Хууль зүйн мэдлэг, мэдээллийг иргэдэд түгээж, хуульчийг иргэдтэй холбох гүүр болдог, иргэдэд тулгарч байгаа асуудал, бэрхшээлийн хүрээнд хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийдэг, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бодлого, үйл ажиллагааг эрс эсэргүүцдэг, олон нийтийн дэмжлэгийг хүлээсэн бодлогын байгууллага байх ёстой.

Миний бие нь “**Шинэ бодлого, шинэ арван**” уриатайгаар Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчид нэрээ дэвшүүлж байна. Шинэ бодлогыг хамтдаа эхлүүлцгээе.

### **БАРИМТЛАХ БОДЛОГО, ЗАРЧИМ:**

**Хуульчдын холбоо**-Хуульчийн мэргэжлийн нэр хүндийг тууштай хамгаалдаг, аливаа сонирхол, нөлөөллөөс ангид, бие даасан хараат бус байгууллага болох ёстой.

**Хуульчдын холбоо**-Дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагатай эн зэрэгцэн хөгждөг, суралцдаг, харилцдаг, үнэлэгддэг байгууллага байх ёстой.

**Хуульчдын холбоо**-Хууль тогтоомж боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мэргэжлийн туслалцаа үзүүлэн бодлогын нөлөөлөл үзүүлдэг, хуульчдын дуу хоолойг хүргэдэг мэргэжлийн нөлөө бүхий байгууллага байх ёстой.

**Хуульчдын холбоо**-Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг дэмждэг, мэргэжил ур чадварыг дээшлүүлэхэд онцгой анхаарч, Монголын хуульчдын хөгжлийн төв байх ёстой.

## МӨРИЙН ХӨТӨЛБӨР

### Нэг. Хуулийн бодлогын чиглэлээр

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлуулахад УИХ, түүний Байнгын хороод, Ажлын хэсгийн түвшинд нягт уялдаа холбоотой хамтран ажиллаж, хуулийн төслийг батлуулж, хэрэгжүүлэхэд манлайлж ажиллана.
2. Хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх чиг үүргийг бодитоор хэрэгжүүлэх, шинээр боловсруулах хуулийн төсөлд бодлогын нөлөөллийн ажлыг зохион байгуулж, хууль санаачлагч нартай хамтран ажиллана.
3. Гадаад харилцааг эрчимтэй сэргээн хөгжүүлж, Олон Улсын байгууллагуудтай хамтран ажиллах, хуульчдыг гадаад зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах гарцыг нээнэ.
4. Холбооны Зөвлөлтэй нягт уялдаа холбоотой хамтран ажиллаж, хууль дүрэмд заасан бодлогын шийдвэрүүдийг цаг алдалгүй гаргаж, тогтмол мэдээлдэг, хэрэгжилтийг үе шат бүрээр тайлагнадаг болгоно.
5. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Өмгөөллийн тухай хуульд заасан чиг үүргийн давхардлыг арилгаж, өмгөөлөгч давхар гишүүнчлэлийн татвар, хураамж төлдөггүй болгоно.
6. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны өмгөөлөгчийн эрх, үүргийн зохицуулалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгаж, нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг хууль тогтоогчтой хамтран хэрэгжүүлнэ.
7. Холбоо нь Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурор, Монголын Өмөөлөгчдийн холбоо, Монголын нотариатчдын танхим болон мөрдөх чиг үүргийн байгууллагуудтай нягт хамтарч ажиллана.

### Хоёр. Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр

1. Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн тохиолдол бүрт тэдгээрийн эрхийг хамгаалж, “Хуульчийн индэр”-ийг тогтмол ажиллуулж, бүх хуульчдын дуу хоолой болж ажиллана.
2. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны эрх зүйн баталгааг хангах, хуульчийн ажлын ачааллыг бууруулах, хараат бусаар ажиллах, холбогдох хуулийн зохицуулалтыг

боловсронгуй болгох талаар УИХ, ЗГ, ШЕЗ, УДШ, УЕП, ЦЕГ зэрэг байгууллагуудад тодорхой санал санаачлага гаргаж, шийдвэрлүүлж ажиллана. Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хорооны үйл ажиллагааг идэвхжүүлж, бодитоор дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллана.

3. Шүүхийн бус журмаар хэрэг, маргааныг шийдвэрлэх бодлого, үйл ажиллагааг эрчимтэй дэмжиж, хөгжүүлнэ.
4. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг буюу шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч, хуулийн зөвлөх, шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга гэх мэт ажлын онцлогийг олон нийтэд сурталчлан таниулах, үнэлэмж-бахархах сэтгэгдэл төрүүлэх цуврал нөлөөллийн ажлыг хийнэ.
5. Холбооны шагналуудыг нийт гишүүдийнхээ оролцоонд тулгуурлан нээлттэй, ил тодоор шалгаруулдаг, олгодог байхаар журмыг илүү боловсронгуй болгоно.

### **Гурав. Хуульчдын мэргэшүүлэх чиглэлээр**

1. Хуульчдын үргэлжилсэн болон мэргэшсэн сургалтыг гишүүдийн саналыг авч, тэдгээрийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн явуулж, сургалтын чанарыг оролцогчдын өгсөн үнэлгээгээр дүгнэдэг болгож, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгоно.
2. Хуульчдыг олон улсын байгууллагуудад зочин судлаачаар оролцуулах болон эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэгт хамруулах, өгүүлэл, нийтлэлийг нь хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлж, сургалтын тодорхой багц цагт тооцдог болно.
3. Хуульчдын үргэлжилсэн болон мэргэшсэн сургалтын агуулга, чанар, заавал эзэмшвэл зохих ахисан түвшинд суурилсан тогтолцоотой уялдуулна.
4. Ахмад хуульчдаас суралцах, туршлага судлах, мэдлэгээ хуваалцах сар бүрийн өдөрлөг арга хэмжээг зохион байгуулж, гишүүд, олон нийтэд тогтмол мэдээлдэг болгоно.
5. Хуульчдын холбоог судалгаа, эрдэм шинжилгээний бодлогын ажлыг манлайлан гүйцэтгэдэг хууль зүйн бодлогын төв болгохын төлөө ажиллана.
6. Гадаадын зочин, сургагч багш нар мэргэшүүлэх чиглэлийн сургалт явуулах боломжийг нээж, хууль зүйн мэргэжлийн гадаад хэлний сургалтыг тогтмол явуулж чадавхийг нэмэгдүүлнэ.

### **Дөрөв. Цахим хөгжлийн чиглэлээр**

1. Хуульчийн сонгон шалгаруулах шалгалтын цахим системийн ажиллагаа, үр дүнг нээлттэй, ил тод болгож шударгаар шалгах, шалгуулах нөхцөлийг бүрдүүлнэ.
2. Гишүүн бүрт мэдээлэл, үйлчилгээг нэн даруй шуурхай хүргэдэг, санал, хүсэлтийг нь авдаг, хариу, үр дүнг мэдээлдэг цогц цахим хуульч аппликейшнийг хэрэглээнд нэвтрүүлнэ.
3. Цахим хавтаст хэрэг, цахим шүүх хуралдаан, цагдан хорих байр болон хорих ангид хоригдож буй үйлчлүүлэгчтэй цахимаар уулзалт хийх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарч ажиллана.

4. Залуу, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй, хүндэтгэн үзэх шалтгаан бүхий хуульчдад байнгын болон түр, цагийн ажлын байрыг бий болгох цахим платформуудтай хамтран ажиллана.
5. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг явуулахад дэмжлэг үзүүлэх цахим технологийн хөгжил, ололтыг сорчлон үе шаттайгаар нэвтрүүлнэ.

**Тав. Санхүү, төсвийн чиглэлээр**

1. Холбооны өнгөрсөн хугацааны санхүүд хөндлөнгийн аудитын шалгалт оруулж тайлан, үр дүнг гишүүддээ нэн даруй мэдээлж, холбогдох арга хэмжээг авна.
2. Холбооны санхүүгийн мэдээллийг шилэн болгож, санхүүжилтийг нээлттэй, ил тод болгож, тогтмол мэдээлдэг болгоно.
3. Холбооны бүтэц, бүрэлдэхүүнийг цомхон, чадварлаг болгож, хуульч таны татварыг үр ашигтай захиран зарцуулна.
4. Хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын хувьд үйл ажиллагаагаа бие даасан, хараат бус байдлаар явуулах өөрсдийн байртай болгоно.
5. Холбооны тогтсон орлогод зөвхөн найдах бус, орлогын шинэ эх үүсвэрийг эрэлхийлж, санхүүгийн нөөцийг нэмэгдүүлнэ.
6. Хууль тогтоомжийн төсөл боловсруулахад Ерөнхийлөгч, УИХ, ЗГ-тай хамтарч ажиллана.